

126



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар

5/21

Номгон

Малын гоц халдварт Шүлхий өвчнийг
тархаахгүй байх, урьдчилан сэргийлэх
талаар авах зарим арга хэмжээний тухай

Олон Улсын худалдааны хорио цээрт мал амьтны гоц халдварт Шүлхий өвчний халдварын анхны батлагдсан тохиолдол Баянхонгор аймгийн Хүрээмарал сумд 2021 оны 08 дугаар сарын 22-нд малын худалдаа эрхлэгчдийн хулгайн замын малын шилжилт хөдөлгөөнөөр зөөвөрлөгдөн халдварласан байна. Мөн Засгийн газрын 43-р тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/43, А/184 дүгээр захирамжийг зөрчсөн малчдын хариуцлагагүйгээс Жинст, Богд, Өлзийт, Баацагаан, Шинэжинст, Бууцагаан, Баян-Овоо, Заг зэрэг сумдад шүлхий өвчний голомт нэмэгдэж, нийт 20 голомтод 78 өрхийн 38027 мал сүргээс 4538 толгой мал өвчилсөн. Малын гоц халдварт шүлхий өвчний голомтыг яаралтай устгах, халдварлалтыг таслан зогсоохоор холбогдох сумдууд Хорио цээрийн дэглэм тогтоосон.

Малын гоц халдварт, халдварт, шимэгчлэх өвчний гаралтыг таслан зогсоох, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын баталгаажуулалт хийх, шинжилгээний нэр төрөл стандартыг нэмэгдүүлэхэд эрүүл ахуйн шаардлага хангасан мал эмнэлгийн лабораторийн байртай болох, малчид мал бүхий иргэд гарал үүсэл нь тодорхой баталгаажсан мал эмнэлгийн гэрчилгээтэй мал амьтны хөдөлгөөн, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулдаг байх, шүлхий өвчнөөр өвчилсөн шинж тэмдэг бүхий 4538 толгой малыг OIE-ийн заавар журмын дагуу дулааны аргаар боловсруулж зах зээлд нийлүүлэх, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу төвлөрүүлсэн хөрөнгийн 30 хүртэл хувийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үзлэг тандалт шинжилгээнд зарцуулах зэрэг тулгамдсан асуудлуудыг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "л", 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус V хуралдаанаас ТОГТООХ нь:

0121046

1. Малын гоц халдварт Шүлхий өвчнийг тархаахгүй байх, урьдчилан сэргийлэх, зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

1.1. Аймгийн хэмжээнд Малын гоц халдварт Шүлхийгээр өвчилсөн 4538 толгой малыг дулааны үйлдвэрийн аргаар боловсруулах, худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх

1.2. Мал эмнэлгийн газрын лабораторийн барилгыг шинээр барихад шаардагдах санхүүжилтийг 2022 оны төсөвт тусган шийдвэрүүлэх

1.3. Малчин, мал бүхий иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох, малын гоц халдварт Шүлхий өвчнийг нуун дарагдуулсан, уг өвчнийг тарааж хууль зөрчсөн буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэн бүх төрлийн хохирлыг барагдуулах арга хэмжээг авах

1.4. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу ОНХС-д төвлөрсөн хөрөнгийн тодорхой хэсгийг малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, тандалтын үйл ажиллагаанд зарцуулах талаар сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлэх

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д даалгасугай

ДАРГА  Э.ЭНХБАТ

